



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/155

Чингис хот

Төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээг
хүлээлцэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 заалт, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 7 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Галшар, сумын төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээг “Хангай Илч” ХХК-д хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэвчтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Дарханбаатар	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Д.Эрхэмбаяр	Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн
Гишүүд:	Б.Гантөгс	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга
	О.Сэдэд	Өмчийн бүртгэл, ашиглалт, хяналтын мэргэжилтэн
	О.Баярмаа	Галшар сумын Засаг даргын орлогч
	П.Цогбадрах	Галшар сумын Санхүүгийн албаны дарга
	Б. Бямбадорж	“Хангай Илч” ХХК-ийн захирал

2. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Дарханбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

• 231010427